

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛТАЙ БАЙГУУЛАХ
ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр

№ 01/73

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллагад шударга, ил тод, хариуцлагатай, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлж, ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг сахиулах, иргэдэд хүргэх төрийн болон нийгмийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх, харьяа байгууллагын удирдах ажилтны хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, эцсийн үр дүнг үнэлж, дүгнэхэд оршино.

1.2., Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон нэг талаас Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар (цаашид "Нийслэлийн Засаг дарга" гэх), нөгөө талаас Налайхын үйлдвэрлэл, технологийн парк ХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Раднаабазар нар (цаашид "Удирдах ажилтан", хамтад нь "Талууд" гэх) 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал 1 жилийн хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулав.

1.3. Талууд Засгийн газрын гишүүнтэй Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2025 онд хамтран ажиллах гэрээ, Засгийн газрын 2020 оны "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам" 217 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам" 206 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "Нийслэлийн 2025 оны төсөв батлах тухай" 24/33 дугаар тогтоол, энэхүү гэрээний хугацаанд баталсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолыг тус тус хэрэгжүүлж ажиллана.

1.4. Монгол Улсын Засгийн газраас "2025 оныг нийслэлийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд холбогдох талуудтай уялдааг хангаж, шуурхай хамтран ажиллана.

1.5. Тухайн байгууллагын "гүйцэтгэлийн төлөвлөгөө" нь энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд түүнд төсвийн шууд захирагчаас тухайн жилд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, төсөв, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин, хугацаа, хариуцах нэгжийг тусгана.

Хоёр. Удирдах ажилтны хүлээх үүрэг

2.1. Удирдах ажилтан энэхүү гэрээгээр дараах үүрэг хүлээнэ:

2.1.1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн Хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах;

2.1.2. Засгийн газрын гишүүнтэй Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2025 онд хамтран ажиллах гэрээнд туссан арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, гэрээнд заасан хугацаанд тайлагнах;

2.1.3. Байгууллагын албан хаагчийн хандлага, ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах;

2.1.4. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаарх аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэл үр дүнг тайлагнаж, Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцах;

2.1.5. Хууль, дүрмээр хүлээсэн чиг үүрэг, энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийг бүрэн хэрэгжүүлэх ба байгууллагын чиг үүргийн хүрээнд Нийслэлийн Засаг даргыг шүүхийн байгууллагын өмнө төлөөлж, гарсан үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцах;

2.1.6. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль болон хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хотын аж ахуйн асуудлаар Улаанбаатар хотын Ерөнхий менежертэй хамтран ажиллах;

2.1.7. Шаардлагатай тохиолдолд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Нийслэлийн Засаг дарга батлахаар заасан захиргааны хэм хэмжээний актыг холбогдох хуульд нийцүүлэн боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэх, батлагдсан дүрэм, журам, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

2.1.8. Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж бодит үр дүнг дээшлүүлэх, тогтоосон хугацаанд тайлагнах;

2.1.9. Ажилтны сахилга хариуцлага, хандлага, ёс зүй, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэхэд анхаарал хандуулж ажил, арга хэмжээ зохион байгуулах;

2.1.10. Иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлэх;

2.1.11. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нийслэлийн удирдлагын шийдвэр, удирдамжийн дагуу хийгдэж буй албаны, хэсэгчилсэн, гүйцэтгэлийн шалгалтын үеэр хяналт хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтны хууль ёсны шийдвэрийг биелүүлэх;

2.1.12. Нийслэлийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ний А/1024 тоот захирамжаар батлагдсан хотын хөгжлийн индексийг тооцох 86 үзүүлэлтээс өөрийн

байгууллагын чиг үүрэгт хамаарах үзүүлэлтийг 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд уялдуулах;

2.1.13.Хотын хөгжлийн индексийн тооцох суурь, анхдагч мэдээллийн чанарыг сайжруулж, орон зайн болон шаардлагатай статистик мэдээллийг Нийслэлийн статистикийн газар, Нийслэлийн бодлогын судалгаа шинжилгээний төвтэй хамтран боловсруулж, хүрсэн үр дүнг 2025 оны жилийн эцсийн байдлаар шинэчлэн тооцох;

2.1.14.Чиг үүргийн хүрээний үндэсний болон хотын стандарт, нормын хэрэгжилтийг хариуцан, иргэн, хуулийн этгээдэд сурталчлан таниулж мөрдүүлэх, хяналт тавих, тухай бүр тайлагнаж бодит үр дүнг сайжруулах;

2.1.15.Чиг үүргийн хүрээнд хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайланг өөрийн цахим хуудас болон төрийн үндэсний судалгааны нэгдсэн системд тухай бүр нийтэлж, дүн шинжилгээ хийх;

2.1.16.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариуг өгөх, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, тодорхой арга хэмжээ авах;

2.1.17.Нийслэлийн удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг тухай бүр нь биелүүлж, явц үр дүнг тайлагнах, нийслэлийн удирдлага, Засаг даргын Тамгын газраас хүргүүлсэн чиглэл, албан бичгийн хариуг шуурхай өгөх, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.1.18.Энэхүү гэрээний хавсралт болох "Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан нийт арга хэмжээний биелэлтийг арга хэмжээ нэг бүрээр хэрэгжүүлэн холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах;

2.1.19.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу байгууллагын даргын шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх бөгөөд холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор UBlegal.ulaanbaatar.mn цахим хуудаст байршуулж, өөрийн цахим хуудас болон олон нийтэд мэдээлэх;

2.1.20.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах;

2.1.21.Гадаад харилцааны чиглэлийн үйл ажиллагаа, арга хэмжээний талаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газартай зөвшилцөж, уялдуулах;

2.1.22.Хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар хэрэгжүүлж буй аливаа арга хэмжээний талаарх мэдээллийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэстэй зөвшилцөж, мэдээллийг нэгдсэн нэг урсгалаар түгээх.

Гурав.Нийслэлийн Засаг даргын хүлээх үүрэг

3.1.Нийслэлийн Засаг дарга энэхүү гэрээгээр дараах үүрэг хүлээнэ:

3.1.1.Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний бүх шатны агентлаг, харьяа байгууллагын ажлын уялдаа холбоог хангаж, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан үйлчилгээний шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлж, хариуцлагыг сайжруулах чиглэлээр зохих арга хэмжээг авах;

3.1.2.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн Хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлж байгаа байдалд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх; хэрэгжилтийг хангах ажлыг нэгдсэн удирдлагаар хангах;

3.1.3.Харьяа байгууллагад төсвийн зардлыг хэмнэх, төсвийн зарлагын үр өгөөжийг нэмэгдүүлэх, улс, орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний чанар, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, удирдлага, зохион байгуулалтаар хангах;

3.1.4.Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэн, нутгийн захиргааны байгууллагуудад тогтмол зөвлөмж, чиглэл өгч, сургалт, мэдээллээр хангах;

3.1.5.Тухайн төрийн байгууллага болон эрх шилжүүлсний үндсэн дээр бусад байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг хуулийн хугацаанд олгох;

3.1.6.Төрийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий харьяа байгууллагын удирдлагатай байгуулсан гэрээг дүгнэхэд тухайн удирдах ажилтны иргэдэд цахимаар үзүүлсэн үйлчилгээний тоо, чанар, хүртээмжийг харгалзах, үйлчилгээ үзүүлэх үүргээ хангалтгүй биелүүлсэн удирдах ажилтанд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцох;

3.1.7.Ил тод, хэмнэлттэй, үр ашигтай төсвийн бодлогыг хэрэгжүүлж, энэ хүрээнд эдийн засгийн өсөлтийг дэмжиж, төсвийн сахилга батыг чангатган, төсвийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангуулах;

Дөрөв.Гэрээг дүгнэх

4.1.Гэрээний биелэлтийн хагас жилийн тайланг 2025 оны 06 дугаар сарын 25, бүтэн жилийн тайланг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

4.2.Гэрээний хавсралт болох "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө"-ний жилийн эцсийн биелэлтийг "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу үнэлнэ.

Тав.Гэрээний хариуцлага

5.1.Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлээгүй, гэрээний хавсралт болох "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан арга хэмжээг дутуу гүйцэтгэсэн, өмнөх үр дүнг бууруулсан, хүрэх түвшинд хүргээгүй, сахилга, хариуцлага алдсан, ёс зүйн зөрчил гаргасан бол Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг

сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

Зургаа.Бусад зүйл

6.1.Талууд гэрээнд тусгагдсан үүргээ харилцан биелүүлнэ.

6.2.Гэрээг хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд талууд харилцан бичгээр санал тавьж, зөвшилцөн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

6.3.Гэрээнд өөрчлөлт орсон тохиолдолд гэрээг баталгаажуулан гарын үсэг зурж, хоёр хувь үйлдэх бөгөөд энэхүү өөрчлөлт нь энэ гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ.

6.4.Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж, талууд тус тус 1 хувийг хадгална.


ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ,
ТЕХНОЛОГИЙН ПАРК ХК-ийн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ч.РАДНААБАЗАР

ATA14401 9025010818 5890683

Төлөөлөгөөг хянасан:

Төсвийн Ерөнхийлөн захирагч

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР

Төлөөлөгөө баталсан:

Төсвийн Шууд захирагч

"НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК"
ХУВЬЦААТ КОМПАНИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.РАДНААБАЗАР

"НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК"
ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ATAH401 902500000 5390683

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая.төг) Эх үүсвэр	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа I-IV улирал/	Хариуцах нэгж
НЭГ. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго: МУЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр: 1.2.1.3, 3.3.1.8, Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөө:1.2.3.3 Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлнэ. НЗДҮАХ - 3.3.1, 3.3.2, Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө 229. Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн, дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркуудыг үе шаттайгаар байгуулна.							
1.1	Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн дулааны станц барих хөрөнгийн эх үүсвэрийг улс нийслэлийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийх нөхцөл боломжийг судлах	-	Ажлын гүйцэтгэл, хувь	Зураг төсөв хийгдсэн 30%	40	I-IV улирал	НҮТП ХК
1.2	Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн инженерийн шугам сүлжээний төсвийг шинэчлэх, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг судлах	-	Ажлын гүйцэтгэл, хувь	Зураг төсөв хийгдсэн 30%	40	I-IV улирал	НҮТП ХК

ХОЁР. Стратегийн төлөвлөгөөний зорилго . Паркийн дэд бүтэц, бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтыг татах

2.1	Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн барилгын материалын бөөний болон жижиглэн худалдааны төвийн ХЕТ боловсруулах ажлыг эхлүүлэх	-	Ажлын гүйцэтгэл, хувь	60 га газрын гэрээ, гэрчилгээ гарсан 10%	40	I-IV улирал	НҮТП ХК
2.2	Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн инженерийн дэд бүтцийн барилга байгууламжуудын гадна цахилгаан хангамжийн зураг төсөв боловсруулах ажлыг эхлүүлэх	-	Ажлын гүйцэтгэл, хувь	Дэд бүтцүүдийн зураг хийгдсэн. 10%	40	I-IV улирал	НҮТП ХК
2.3	Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн ТЭЗҮ, Хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг эхлүүлэх	-	Ажлын гүйцэтгэл, хувь	2014 онд хийгдсэн ТЭЗҮ шинэчлэх шаардлагат ай 20%	100	I-III улирал	НҮТП ХК
2.4	Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн 250 га газарт техник технологийн түвшний үнэлгээ хийлгэх	-	Ажлын гүйцэтгэл, хувь	120га газарт хийгдсэн ТТҮнэлгээн ий хугацаа дууссан	100	I-III улирал	НҮТП ХК
2.5	Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх	-	Ажлын гүйцэтгэл, хувь	Газрын гэрээ, гэрчилгээ гарсан 20%	100	I-III улирал	НҮТП ХК
2.6	Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн 310 га газрын хянан баталгаа хийлгэх	Өөрийн үйл ажиллагааны орлогоос 21,5	Ажлын гүйцэтгэл, хувь	Газрын гэрчилгээ гарсан	100	I-III улирал	"НҮТП" ХК
Дүн		21.5					

ГУРАВ. Зорилт 3. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт. – Парктай холбоотой хууль тогтоомж, эрх зүйн акт, дүрмээр тогтоосон чиг үүргийг хэрэгжүүлэх, бодлого боловсруулах, зохицуулах, зохион байгуулах, боловсон хүчнийг бүрдүүлэх, чадавхжуулах, нийгмийн баталгааг хангаж хэрэгжилтийг зохион байгуулан ажиллана.

3.1	Нийслэлд боловсруулах үйлдвэр байгуулах болон түүнтэй холбоотой дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэхээр ажиллаж буй төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах	-	Хэрэгжилт хувиар	0	100	I-IV улирал	"НҮТП" ХК
3.2	Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр авах	-	Ажлын гүйцэтгэл хувь	2017 онд 5 жилийн хугацаатай тусгай зөвшөөрөл авсан	100	III улирал	НҮТП ХК
3.3	Төрийн захиргааны төв байгууллагатай паркийн үйл ажиллагаа эрхлэх гэрээ байгуулан ажиллах	-	Хэрэгжилтийн хувь	0	100	I-IV улирал	НҮТП ХК
3.4	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнаж ажиллах /Дүрмийн сан	Нийслэлийн төсөв 600.0	Хэрэгжилтийн хувь	НАГ-т 2024 оны санхүүгийн тайланг шалгуулж зөрчилгүй санал дүгнэлт авсан -	100	I-IV улирал	"НҮТП" ХК
3.5	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах		Ажлын гүйцэтгэл, хувь		100	I-IV улирал	НҮТП ХК

3.6	Улс, нийслэлийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2025 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж хугацаанд нь чанартай гүйцэтгэх	-	Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	"НҮТП" ХК
3.7	Байгууллагын албан хаагчид болон паркийн нэгжүүдийн ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх	-	Хэрэгжилтийн хувь	-	30%	I-IV улирал	"НҮТП" ХК
3.8	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг ханган төлөвлөгөө гарган ажиллах	-	Ажлын гүйцэтгэлийн хувь	-	100	I-IV улирал	"НҮТП" ХК
3.9	Паркт үйлдвэрлэдэг бүтээгдэхүүнээр төр, засгийн газрын худалдан авалтыг хангах төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж паркийн аж ахуйн нэгжүүдтэй худалдан авах гэрээ байгуулах боломжийг судлах	-	Ажлын гүйцэтгэл, хувь	-	50%	I-IV улирал	"НҮТП" ХК
3.10	Налайхын мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв болон бусад мэргэжлийн сургалтын төвүүдтэй хамтран үйлдвэрүүдийн ажилтан, албан хаагчдад мэргэжил дээшлүүлэх, чадавхжуулах сургалт зохион байгуулах	-	Үйлдвэрүүдийн албан хаагчыг сургалтад зуучлах, сургалт зохион байгуулсан тоо	-	2	I-IV улирал	"НҮТП" ХК

3.11	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах	-	Хуулийн хэрэгжилтийг хангасан байна	-	100	I-IV улирал	"НҮТП" ХК
3.12	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийг хэрэгжүүлж төлөвлөгөө гарган ажиллах	-	Гүйцэтгэлийн хувь	-	100	I-IV улирал	"НҮТП" ХК
3.13	Хот төлөвлөлт, хот байгуулалтын стандартын барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага UCS 0301 В-г таниулах ажлыг зохион байгуулан хэрэгжилтэд хяналт тавих	-	Паркт байршиж буй аж ахуйн нэгжүүдэд танилцуулах мөрдлөг болгон ажиллах ажлыг зохион байгуулсан байх	-	100	I-IV улирал	"НҮТП" ХК
	Дүн	600.0					
ДӨРӨВ. Зорилт 4 -Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.							
4.1	Төрийн албан хаагчид ёс зүйн асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, удирдамж, заавраар хангах, сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах боломж, нөхцөл бүхий орчныг бүрдүүлж, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	100	I-IV улирал	"НҮТП" ХК

4.2	Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлэх, хэвшүүлэх, баримтлан ажиллахад чиглэсэн үйл ажиллагааг байгууллагын удирдлага манлайлан, Ёс зүйн дэд хорооны дэмжлэгтэйгээр тогтмол хэрэгжүүлнэ	-	Хуулийн хэрэгжилтийг хангасан байна	-	100	I-IV улирал	"НҮТП" ХК
4.3	Ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэхэд иргэний нийгэм, хувийн хэвийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог хангана	-	Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	"НҮТП" ХК

ТАВ. Зорилт 5 – Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг бүрэн хангана.

5.1	Авлага, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах	-	Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	"НҮТП" ХК
5.2	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2030 он)-г хэрэгжүүлж, Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ	-	Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	"НҮТП" ХК

ЗУРГАА. Зорилт 6. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт. Үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах

6.1	Төлөөлөн Удирдах Зөвлөлтэй хамтран ажиллаж паркийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагааг эрчимжүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	I-IV улирал	"НҮТП" ХК
6.3	Хариуцсан чиг үүргийн хүрээнд үүргийн шинжилгээ хийж, засаглалын тогтолцоог оновчтой болгох замаар үр ашгийг нэмэгдүүлж, удирдлагын тогтолцоонд реформ хийх ажлыг эхлүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	I-IV улирал	"НҮТП" ХК
6.4	MNS ISO 900152016 – чанарын менежментийн тогтолцооны стандарт нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	I-IV улирал	"НҮТП" ХК
6.5	Хяналт, мониторингийн тогтолцоог сайжруулж, олон улсын үнэлгээний систем нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	I-IV улирал	"НҮТП" ХК
6.6	Хариуцсан чиг үүргийн хүрээний албан ёсны болон захиргааны статистик мэдээллийг боловсруулах, тайлагнах тогтолцоог хөгжүүлэх ажлыг эхлүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	I-IV улирал	"НҮТП" ХК

6.7	Байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	I-IV улирал	"НҮТП" ХК
6.8	Гадаадын улс орон, дотоодын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд байгууллагын танилцуулгыг гадны 3 хэл дээр хөрвүүлэх, гадны туршлага судлах	Өөрийн үйл ажиллагааны орлого 49.0	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	3	I-IV улирал	"НҮТП" ХК
6.9	Албан хаагчдын мэргэжил ур чадварыг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, хүний нөөцийн төлөвлөгөө гаргаж ажиллах	Өөрийн үйл ажиллагааны орлого 3.0	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	100	I-IV улирал	"НҮТП" ХК
6.10	Паркт үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг борлуулах нэгдсэн вэб сайт нээх	Өөрийн үйл ажиллагааны орлого 4.5	Хэрэгжилтийн хувь	-	100	I-IV улирал	"НҮТП" ХК
6.11	Аюулгүй ажиллагааны хувцас хэрэгсэл, гамшгийн үед шаардагдах багаж хэрэгслээр хангах	Өөрийн үйл ажиллагааны орлого 5.0	Хэрэгжилтийн хувь	-	100	I-IV улирал	"НҮТП" ХК
6.12	Хурал, зөвлөгөөн уулзалтын өрөө тохижуулах, гадна дотны хөрөнгө оруулагчдыг хүлээн авах, танилцуулга мэдээлэл өгөх	Өөрийн үйл ажиллагааны орлого 10.5	Хэрэгжилтийн хувь	-	100	I-IV улирал	"НҮТП" ХК
Дүн		72.0					

ДОЛОО. Зорилт 7. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт. Төрийн үйлчилгээг ил тод, хурдан шуурхай, чанартай, хүртээмжтэй хүргэх.

7.1	Паркийн оффисын барилгын дулаан, цэвэр бохирын шугам болон гадна фасадын засварын ажлыг гүйцэтгэх	Өөрийн үйл ажиллагааны орлого 167.9	Гүйцэтгэлийн хувь	2016 онд ашиглалтад орсноос хойш их засварт орж байгаагүй.	100	II-IV улирал	"НҮТП" ХК
7.2	Гадаадын болон дотоодын байгууллагуудад мэдээлэл хүргэх, уулзалт зөвлөгөөнд оролцох, зохион байгуулах	Өөрийн үйл ажиллагааны орлого 14.1	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	5	I-IV улирал	"НҮТП" ХК
7.3	"Эрүүл Монгол Хүн" үндэсний хөтөлбөрийн хүрээнд албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах чийрэгжүүлэх, идэвхжүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Өөрийн үйл ажиллагааны орлого 7.0	Ажлын гүйцэтгэл, хувь	-	100	I-IV улирал	"НҮТП" ХК
7.4	Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээг цахимжуулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авч, байгууллагын үйл ажиллагааг нээлттэй болгох замаар хүнд суртлыг багасгах,	-	Байгууллагын сайт, цахим хуудасны ашиглалтын хувь	-	100	I-IV улирал	"НҮТП" ХК
7.5	Байгууллагын үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулах	Өөрийн үйл ажиллагааны орлого 15.0	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	3	I-IV улирал	"НҮТП" ХК

7.6	"Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр (2024-2030 он)" хүрээнд төлөвлөгөө гарган ажиллах	-	Хэрэгжилтийн хувь	-	100	I-IV улирал	"НҮТП" ХК
7.7	Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III", "Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага MNS6395:2022"-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах, хос бичгээр албан хэрэг хөтлөлт явуулах	-	Хэрэгжилтийн хувь	-	100	I-IV улирал	"НҮТП" ХК
Дүн		204.0					
НАЙМ. Зорилт 8. Бүтээн байгуулалтын жилийн хүрээнд хэрэгжүүлэх зорилт							
8.1	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд ААН-ын ногоон байгууламжийг нэмэгдүүлж, мод тарих арчлах	-	Тарьсан модны тоо	10	30	II-III улирал	"НҮТП" ХК
8.2	Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн аж ахуйн нэгжийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх	-	Шинээр ашиглалтад орсон үйлдвэрийн тоо	3	8	I-IV улирал	"НҮТП" ХК
8.3	Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн цэвэрлэх байгууламж барих ажлыг эрчимжүүлэх	-	Ажлын гүйцэтгэл, хувь	Зураг төсөв хийгдсэн 30%	20%	I-IV улирал	"НҮТП" ХК
Дүн: Нийслэлийн төсөв		600.0					
Өөрийн үйл ажиллагааны орлого		297.5					
Нийт дүн		897.5					